

**БАТЛАВ.**

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал  
жуулчлалын газрын дарга

**ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ  
ХҮЛЭЭСЭН.**

Клин Энержи Ази ХХК-ийн Захиргаа,  
удирдлагын газрын захирал Б. Баярмаа



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМ СИЙРСТ БАГТ БАЙРЛАХ  
“ЦЭЦИЙ САЛХИН ЦАХИЛГААН СТАНЦ”-ЫН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

(Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 5648343)

Хянасан:

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн .....

Биелэлтийг тайлагнасан:

Клин Энержи Ази ХХК-ийн Гүйцэтгэх захирал ..... Р. Мягмар

Клин Энержи Ази ХХК-ийн БО, ХАБЭА-н менежер ..... Д.Саруул

2022 он

## ГАРЧИГ

1. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	4
1.1. Станцын ашиглалт хариуцагч:.....	4
1.2. Төлөвлөгөөний гүйцэтгэл буюу үйлдвэрлэсэн цахилгана эрчим хүчний хэмжээ .....	4
1.3. Станцын байршил, засаг захиргааны харьяалал .....	4
1.4. Станцын товч мэдээлэл .....	5
1.5. Техник технологи, тоног төхөөрөмжийн мэдээлэл .....	5
1.6. Дэд бүтэц .....	5
1.7. Станцын байгаль орчинд үзүүлэх шууд эерэг нөлөөлөл.....	5
1.8. Байгаль орчинтой холбоотой авсан зөвшөөрөл, тайлан, төлөвлөгөө.....	5
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	7
2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	8
2.2. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .....	10
2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .....	12
2.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .....	14
2.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .....	14
3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	16
3.1. Техникийн нөхөн сэргээлт .....	16
3.2. Биологийн нөхөн сэргээлт.....	16
3.3. Орчны тохижилт .....	17
4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	18
5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	18
6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	20
7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	22
8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..	32
9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	37
10. ДҮГНЭЛТ .....	39

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн эзэмшдэг тусгай зөвшөөрөл болон тайлан.....	5
Хүснэгт 2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөөний биелэлт .....	8
Хүснэгт 3. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт .....	10
Хүснэгт 4. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт.....	12
Хүснэгт 5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт.....	14
Хүснэгт 6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт .....	14
Хүснэгт 7. Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар, байршил, хэмжээ.....	16
Хүснэгт 8. Осол, эрсдэл, гамшгаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	18
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	21
Хүснэгт 10. Орчны агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт.....	23
Хүснэгт 11. Хөрсний элэгдэл, чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт .....	24
Хүснэгт 12. Усны чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт.....	27
Хүснэгт 13. Ургамлан нөмрөгийн хяналт шинжилгээний биелэлт.....	28
Хүснэгт 14. Амьтны аймгийн хяналт шинжилгээний биелэлт .....	29
Хүснэгт 15. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал .....	33
Хүснэгт 16. Орон нутгийн иргэдэд зориулсан нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажил .....	37

## ЗУРГЫН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн 700 га талбайн ерөнхий зураг .....	4
Зураг 2. Удирдлага зохион байгуулалтын схем .....	32

## 1. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Станцын ашиглалт хариуцагч:

Төсөл хэрэгжүүлэгч: Клин Энержи Ази ХХК  
 Төслийн нэр: 50МВт хүчин чадалтай Цэций салхин цахилгаан станц  
 Үйлдвэрлэх боломжит хүчин чадал: Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 201.8 сая кВт.ц/жил  
 Улсын бүртгэлийн дугаар: 9019065019  
 Регистрин дугаар: 5648343  
 Газар эзэмших гэрчилгээний дугаар: 000303184  
 Станцын туслан гүйцэтгэгч: Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК, Вестас  
 Монголиа ХХК


### 1.2. Төлөвлөгөөний гүйцэтгэл буюу үйлдвэрлэсэн цахилгана эрчим хүчний хэмжээ

Клин Энержи Ази ХХК-ийн суурилагдсан хүчин чадал 50МВт ба жилд үйлдвэрлэх боломжит цахилгаан эрчим хүчний хэмжээ нь 201.8 сая кВт.цаг байдаг. 2022 онд Цэций салхин цахилгаан станц нь төвийн бүсийн нэгдсэн сүлжээ буюу Диспетчерийн үндэсний төвд нийт 123.4 сая кВт/цаг эрчим хүч нийлүүлсэн бөгөөд төлөвлөгөөний биелэлт нь 91.77% гүйцэтгэлтэй байна.

### 1.3. Станцын байршил, засаг захиргааны харьяалал

Цэций салхин цахилгаан станц (цаашид “станц” гэх) нь Улаанбаатар хотоос 542 км зайтай Өмнөговь аймгийн Цогтцэций сум Сийрст багын нутаг дэвсгэрт нийт 700 га талбайд байрладаг (Зураг 1).

Зураг 1. Төслийн 700 га талбайн ерөнхий зураг



#### 1.4. Станцын товч мэдээлэл

50МВ хүчин чадалтай Цэций салхин цахилгаан станц нь 2017 онд баригдаж 2018 онд ашиглалтанд орсон ба төслийн 25 жилийн хугацаанд Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнд жилд 201.8 сая кВт/жил буюу жилд 100,000 айлын цахилгааны хэрэгцээг хангахуйц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж нийлүүлнэ. Станцын эрчим хүч үйлдвэрлэх шуурхай ажиллагаанд нийт 2 ээлжээр 30 гаруй инженер техникийн ажиллагсад ажилладаг.

#### 1.5. Техник технологи, тоног төхөөрөмжийн мэдээлэл

Цэций салхин цахилгаан станц нь ВиV110 моделийн тус бүр 2МВт-ын хүчин чадалтай, 80м булны өндөртэй, 110м роторын диаметртэй нийт 25ш салхин турбин генератор (цаашид “СТГ” гэх), 110/35кВт-н хүчин чадалтай Цэций дэд станц, 34км 110кВт-ын хос хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 18км 35кВт-ын газар доорх цахилгаан дамжуулах кабелийн сүлжээнээс бүрдэнэ.

#### 1.6. Дэд бүтэц

Станц нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас 23км зайтай орших бөгөөд хатуу хучилттай орон нутгийн замаас 4.7 км зайтай оршдог. Дэд станц болон СТГ-уудыг холбосон 15км сайжруулсан шороон зам, орон нутгийн хатуу хучилттай замаас станцруу нэвтрэх 4.7км урттай сайжруулсан шороон зам тавигдсан. Станцын талбайд 30 хүний багтаамжтай засвар үйлчилгээний амралтын байр 1, 4ш сэндвичэн орон сууц, 400м<sup>2</sup> хэмжээтэй бараа материалын агуулах ашиглагддаг.

#### 1.7. Станцын байгаль орчинд үзүүлэх шууд эерэг нөлөөлөл

Цэций станцын байгаль орчинд үзүүлэх шууд эерэг нөлөөлөл бол жилд 230,000 тн хүлэмжийн хийг бууруулж, 180,000 тн нүүрс хэмнэж, 1.2 сая тн ус тус тус хэмнэнэ.

#### 1.8. Байгаль орчинтой холбоотой авсан зөвшөөрөл, тайлан, төлөвлөгөө

Станцын барилга угсралтын ажил 2016 онд эхлэхээс өмнө төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ 2014 онд хийгдсэн. Станцын байгаль орчинтой холбоотой тайлан болон зөвшөөрлийг Хүснэгт 2-т тусгав.

##### *Хүснэгт 1. Төслийн эзэмшдэг тусгай зөвшөөрөл болон тайлан*

№	Тусгай зөвшөөрлийн төрөл:	Олгосон:	Дугаар:	Хугацаа:
<i>Станцын үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл:</i>				
1	Эрчим хүчний барилга байгууламж барих зөвшөөрөл	Эрчим хүчний зохицуулах хороо	28/2014	5 жил
2	Эрчим хүчний барилга, байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл	Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газар	05/2017	2017/02/08 – 2018/02/08
3	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл	Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	2016/18	2016/09/30 – 2017/12/01
4	Төмөр замын трассын ПК13+750 түр гарам байгуулах зөвшөөрөл	Монголын төмөр зам	21/572	2016/07/05 – 2017/12/31
5	Салхин цахилгаан станцыг төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, зөвшөөрөл	Эрчим хүчний яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	38/2015	
6	Архитектур төлөвлөлтийн даалгавар	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	ЗТ/10	

№	Тусгай зөвшөөрлийн төрөл:	Олгосон:	Дугаар:	Хугацаа:
7	Салхин цахилгаан станцын ерөнхий төлөвлөгөө	Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга		
8	Зураг төслийн баримт бичгийн магадлалын ерөнхий дүгнэлт	Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төв	ЕЗ-0004/2016	2016/10/27 – 2018/04/10
<i>Газрын гэрчилгээ, захирамж:</i>				
9	Газар эзэмших эрхийн гэрчилгээ (Төслийн 700 га)	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Газрын алба	000312355	21 жил
10	Иргэн, хуудлийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээ	Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		21 жил
11	Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх тухай захирамж	Өмнөговь аймгийн засаг дарга	a/541	21 жил
12	Бэлчээрийн газрын төлөв байдал чанарын хянах баталгааны дүгнэлт	Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	032	
13	Газар эзэмших эрхийн гэрчилгээ (34 км цахилгаан дамжуулах шугам)	Өмнөговь аймгийн Газрын алба	000312364	60 жил
14	Газар эзэмшүүлэх захирамж (34 км цахилгаан дамжуулах шугам)	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг дарга	a/196	60 жил
<i>Өмнөговь аймгаас авсан зөвшөөрөл:</i>				
15	Цэвэр усаар ханах, бохир усыг төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлэх, цэвэрлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ	Ухаа худаг ус хангамж ХХК – Клин Энержи Ази ХХК	UNGWS-16-008	2016/10/01 – 2017/12/31
16	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф батлах тухай тогтоол - Ухаа худаг ус хангамж ХХК-д цэвэр, бохир усны үйлчилгээ үзүүлэх тариф батлав.	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоол	07	
17	Усны шинжилгээний сорилын дүн – Ухаа худаг ус хангамж ХХК нь MNS900:2010 стандартын шаардлага хангасан болохыг батлав.	Усны шинжилгээний лаборатори	16/71	
18	Итгэмжлэгдсэн лабораторийн сорилийн дүн – Ухаа худаг ус хангамж ХХК нь усны ус MNS0900-2005 стандартын шаардлага хангасан болохыг батлав.	Хими хяналтын лаборатори		
19	Хог хаягдал тээвэрлэх маршрут	Цог-Өрнөх ОНӨААТҮГ		
20	Хог хаягдлын нэгдсэн цэгийн байршил	Цог-Өрнөх ОНӨААТҮГ		
21	Орон нутгийн автозамын трасс тогтоох зөвшөөрөл	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын захирамж	a/118	
22	4.7 км орон нутгийн шороон замыг сайжруулах, засварлах ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг дарга	1-469	

№	Тусгай зөвшөөрлийн төрөл:	Олгосон:	Дугаар:	Хугацаа:
23	Хог хаягдлын түр цэг байгуулах зөвшөөрөл - Төслийн кемпийн хогийн цэг	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг дарга	a/210	
24	Хог хаягдлын түр цэг байгуулах тухай зөвшөөрөл - Засварын талбай - Бетон зуурмагийн үйлдвэр - Шинээр баригдах барилга - Дэд станцын барилга	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг дарга	a/48	
<i>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ</i>				
25	Цогтцэций салхин цахилгаан станцын байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	2014/В049	2014/04/16 батлагдсан.
26	Цэций салхин цахилгаан станцын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам		2014 батлагдсан.
27	Цэций салхин цахилгаан станцын 110кВт цахилгаан дамжуулах агаарын шугам төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	11/2300	2016/05/16 батлагдсан.
28	2016 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам		2016/06/01 батлагдсан.
29	2017 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам		Батлагдсан.
30	2018 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам		Батлагдсан.
31	2019 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам		Батлагдсан.
32	2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам		Батлагдсан.
33	2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам		Батлагдсан.
34	2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам		Батлагдсан.
35	Байгаль орчны нийцлийн төлөвлөгөөт аудит	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	22/11	2022/07/24
36	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам		Батлуулахаар хүлээгдэж байна.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Клин Энержи Ази ХХК нь 2022 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу авсан үүрэг амлалтуудаа бүрэн хэрэгжүүлж байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад онцгой анхаарч ажиллав. Мөн 2022 онд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар бүрэн хийлгэсэн бөгөөд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг дахин хийлгэж улмаар үнэлгээний нэмэлт тодотголыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж батлуулах шатандаа явж байна.

Энэхүү гүйцэтгэлийн тайланг БОНХАЖЯ Сайдын 2019 оны А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын” дагуу боловсруулсан бөгөөд уг баримт бичиг нь эрх зүйн хөдлөшгүй акт биш тул холбогдох баримт бичгийг удирдлага болгон нэмэлт өөрчлөлт оруулж болно.

### 2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт




Компанийн зүгээс хүрээлэн буй орчны агаарын чанарт үзүүлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн (Хүснэгт 2).

#### Хүснэгт 2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөөний биелэлт

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
1.	<p>Машин механизмыг хугацаат техникийн үзлэгт хамруулах, тээврийн хэрэгслийн утааг стандарт түвшинд байлгах</p> <p>Баримт: Үзлэгт, засвар үйлчилгээнд хамрагдсан тээврийн хэрэгслийн бүртгэлийн хуудас</p>	<p>Цэций станцын хэрэгцээнд нийт 2 тээврийн хэрэгсэл ашиглагддаг бөгөөд хүнд оврын машин механизм хэрэглэгддэггүй. 2022 онд автотээврийн хэрэгслийн үзлэгт 2 машин хамрагдсан.</p>	<p>2146 УНП – Toyota land cruiser 70 2022/03/11-ны өдөр үзлэгт орж тэнцсэн.</p>  <p>8449 УБЭ – Toyota land cruiser 70 2022/05/07-ны өдөр үзлэгт орж тэнцэв.</p> 



№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
3.	<p>Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах, амьсгалын замын өвчлөлийг эрт илрүүлэх</p> <p>Баримт: Гэрээ, тайлан</p>	<p>2022 онд станцад шинээр ажилд орж байгаа ажиллагсдыг амьсгалын замын өвчлөл болон бусад төрлийн хууч өвчтэй болохыг эрт тогтоох зорилгоор эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Мөн нийт ажилтны эрүүл мэндийн хугацаат үзлэгийг 21/00470195 дугаартай Мандал даатгалтай байгуулсан “Жаргалан эрүүл мэндийн даатгал”-ын гэрээний дагуу 10/01 – 11/05-ны хугацаанд Рехамед гялс эмнэлэгт зохион байгуулсан. Энэхүү үзлэгт нийт 38 ажилтан хамрагдсан. Мөн амьсгалын замын халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 09/18 – 10/30-ны хугацаанд Фамили Медикал Центр эмнэлэг дээр ажиллагсдын сайн дурын үндсэн дээр томуугийн А хүрээний H1N1 вирус, В хүрээний вирусын эсрэг вакцинжуулалтанд хамруулав.</p>	
4.	<p>Хог хаягдал ил задгай шатаахгүй байх, зориулалтын хог хаягдлын цэгт зайлуулах</p> <p>Баримт: Гэрээ Маршрут</p>	<p>2020/02/19-ны өдөр Тэгш Дүүрэн тохижилт ОНӨААТҮГ-тэй хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураах тээвэрлэх гэрээ байгуулж хатуу хог хаягдлыг орон нутгийн зориулалтын хогын цэгт зайлуулдаг.</p> <p>Станцын талбайд зөвшөөрөл бүхий түр хогийн цэгт хатуу хог хаягдлыг түр ангилан хадгалдаг. Мөн ажиллагсадын амьдрах, ажиллах орчинд хог хаягдал ангилан ялгах зориулалтын хогын савууд байрлуулсан.</p>	

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
			 
5.	Төслийн талбайд хэмжилтийн станц байрлуулж, агаарт үзүүлэх нөлөөллийг хэмждэг.	Цаг уурын 50м болон 80м станц байрлуулсан. NRG системийн салхи цаг уурын станц тогтмол ажиллагаатай.	

**2.2. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт**  
Компанийн зүгээс хүрээлэн буй орчны усны нөөцөд үзүүлж болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн (Хүснэгт 3).

*Хүснэгт 3. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт*

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
---	-------------	-----------	-------



№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
1.	<p>Нефтийн бүтээгдэхүүн, аюултай бодисыг зориулалтын тохижуулсан цэгт, битүүмжтэй хадгалах</p> <p>Баримт: Зориулалтын тохижуулсан цэг</p>	<p>Станцын талбайд ашиглах нефтийн бүтээгдэхүүн бол трансформаторын тос юм. Нийт 10.7 тн трансформаторын тос нь 2 трансформатор дотор эргэлтэнд ашиглагддаг бөгөөд энэхүү тосыг төсөл дуустал ашиглана. Энэхүү тос нь хэвийн горимд 10 жилийн хугацаанд солигдохгүй бөгөөд аливаа гэмтэл аваар саатал гарсан тохиолдолд зориулалтын тохижуулж битүүмжилсэн хаягдал тосны бакт хадгалагдах зориулалттай.</p>	
2.	<p>Аваар ослоос үүдэлтэй асгаралт болсон тохиолдолд хэрэглэх шингээгч материалыг зохих газарт байршуулах</p> <p>Баримт: Асгаралт шингээх материал</p>	<p>Химийн бодис гэнэт асгарах тохиолдолд асгаралт шингээгч материалыг химийн бодисын өрөөнд бэлэн байрлуулсан.</p>	
3.	<p>Төслийн хэрэгцээнд гүний худаг (artesian) гаргах шаардлага гарвал тус</p>	<p>Тайлант хугацаанд гүний усны цооног гаргах шаардлага гараагүй.</p>	<p>-</p>








№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
	худгийг гүний усны хяналтын цооног хэлбэрээр ашиглан усны чанарын өөрчлөлтөнд хяналт тавих, ус ашиглах дүгнэлт авах, гэрээ байгуулж ажиллах		

### 2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Компанийн зүгээс хүрээлэн буй орчны хөрсөн бүрхэвчинд үзүүлж болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн (Хүснэгт 4).

#### *Хүснэгт 4. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт*

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
1.	Хөрс хамгаалах зорилгоор химийн бодисыг зориулалтын хамгаалалтын суурьтай газарт хадгалах	Станцын хэрэгцээнд ашиглагдах химийн бодисыг зориулалтын тохижуулсан дотор агуулах болон тохижуулсан ил агуулахад хөрс бохирдуулахаас сэргийлсэн цементэд суурьтай цэгт хадгалдаг. Аюултай, хортой хог хаягдлыг зориулалтын хаягжуулж, тохижуулсан, хамгаалсан суурьтай цэгт хадгалдаг.	 




№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
2.	Аваар ослоос үүдэлтэй асгаралт болсон тохиолдолд хэрэглэх шингээгч материалыг зохих газарт байршуулах	Химийн бодис гэнэт асгарах тохиолдолд асгаралт шингээгч материалыг химийн бодисын өрөөнд бэлэн байрлуулсан.	
3.	<p>Төслөөс гарч буй хатуу, шингэн бүх төрлийн хог хаягдлыг зохих ангиллын дагуу ангилж, хаягдлын цэгт хаях, хөрс бохирдуулахгүй байх</p> <p>Баримт: Гэрээ, тохижуулсан зориулалтын цэг</p>	<p>2020/02/19-ны өдөр Тэгш Дүүрэн тохижилт ОНӨААТҮГ-тэй хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураах тээвэрлэх гэрээ байгуулж хатуу хог хаягдлыг орон нутгийн зориулалтын хогын цэгт зайлуулдаг.</p> <p>2019/03/04-ны өдөр Ухаа худаг ус хангамж ХХК-тай байгуулсан КЭА-Г-19/06 тоот гэрээ байгуулж бохир усыг төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлж, цэвэрлүүлж, шинжлүүлдэг. Станцын талбарт зориулалтын битүүмжилсэн бохир ус соруулах ёмкос танктай ба гэрээт байгууллагаар тогтмол зөөлгөж зориулалтын цэвэрлэх</p>	<p>ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:</p> <p>ХАНГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: "УХАА ХУДАГ УС ХАНГАМЖ" ХХК            Ц.БААСАНДОРЖ          Гүйцэтгэх Захирал</p> <p>ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: "КЛИН ЭНЕРЖИ АЗИ" ХХК            Э.ОРЧЛОН          Гүйцэтгэх Захирал</p> <p>Л.ОЮУНБАТ          Ерөнхийлөгч</p> <p>ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ "ЭНЕРЖИ РЕСУРС" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:            Г.БАТЦЭНГЭЛ          Гүйцэтгэх Захирал</p> <p>  </p> <p>  </p> <p>  </p>

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
		байгууламжид зайлуулдаг. Бохир усыг хөрсөнд шууд нэвчүүлдэггүй.	

#### 2.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Компанийн зүгээс хүрээлэн буй орчны хөрсөн бүрхэвчинд үзүүлж болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн (Хүснэгт 5).



##### *Хүснэгт 5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт*


№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
1.	Тээврийн хэрэгслийг тогтоосон замаар явуулах, хяналт тавих	Нийт ажиллагсадын дунд “Автомашин ашиглах журам” мөрдөгддөг. Замгүй газраар явахыг хориглосон. Зөрчсөн тохиолдолд зөрчил гаргасан ажилтан тус бүрт зөрчлийн хуудас бичигддэг. Замгүй газраар зорчиж байгаа гадны байгууллагын тээврийн хэрэгслийг хориглох зорилгоор хаалт хийж, автомат гэрэл ажиллуулдаг.	 
2.	Төслийн талбайд байгалийн ургамал түүх, ашиглахыг хориглох зааварчилгаа өгөх	Станц нь “Байгаль орчны бодлого”, “Байгаль орчны зөрчил мэдээлэх журам” хэрэгжүүлдэг. Мөн нийт ажилчидад олгох урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан нийт ажилчидад байгалийн ургамал түүх ашиглахыг хориглосон зааварчилгаа өгдөг.	

#### 2.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Компанийн зүгээс хүрээлэн буй орчны хөрсөн бүрхэвчинд үзүүлж болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн (Хүснэгт 6).

##### *Хүснэгт 6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт*

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
1.	Барилгын ажил, машин механизмын дуу чимээнд хяналт тавих, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд дуу намсгагч байрлуулах	Тайлант хугацаанд орчны дуу чимээний хэмжилтийг 2022/10/15, 16-ны өдөр Грийнтрэнс ХХК гүйцэтгэсэн бөгөөд уг хэмжилтээр 58.15дБА /кемп потор/, 56.1дБА /зам дагуу/ гарсан нь MNS4585:2016 Агаарын чанарын ерөнхий шаардлагатай харьцуулахад зөвшөөрөгдөх хэмжээний шаардлага хангасан байна. Иймд дуу насгагч байршуулах шаардлаггүй гэж үзэв.	
2.	Улаан ном, бүс нутаг болон олон улсын улаан дансанд хамгаалагдсан ховор болон нэн ховор зүйлийн амьтны популяци төслийн талбайд илрэх магадлалтай тул хяналт мониторинг хийх	10 дугаар сарын 15-16-ны өдрийн хооронд хийсэн амьтны аймгийн хяналт шинжилгээгээр 2 зүйл том хөхтөн, 2 зүйл жижиг хөхтөн, 1 зүйл махан идэшт амьтан, 18 зүйлийн шувууд бүртгэгдсэн. Эдгээрээс улаан номд орсон нь цагаан зээр, хар сүүлт байсан бол шувуудаас ооч ёл бүртгэгдэв. Бүс нутгийн хэмжээнд ооч ёл эмзэг, Олон улсын хэмжээнд ховордож болзошгүй, нөмрөг тас Олон улсын хэмжээнд эмзэг гэж тус тус үнэлэгдсэн байна. Мөн хар сүүлт зээр Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд эмзэг, цагаан зээр нь бүс нутгийн хэмжээнд устаж болзошгүй гэж үнэлэгдсэн.	

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Зураг
3.	Төсөл хэрэгжих талбайд агнуур хийхийг хориглох, хяналт тавих	Байгаль орчны бодлого болон урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан нийт ажиллагсдад ан агнуур хийх, Цэций тусгай хамгаалалттай уулуу нэвтрэхийг хориглох санамжыг тогтмол өгдөг.	 <p><b>БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Клин Энержи Ази ХХК нь "Цэций" СЦС-ийн үйл ажиллагааны бүх шатанд байгаль орчинд үзүүлэх гөл болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, удирдах ажилд эмн тэргүүний өгч холбогдож өгч, Монгол Улсын холбогдох кууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэн <b>БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ</b> "АЮУЛГҮЙ ЦАХИЛГААН ҮЙЛДВЭРЛЭХ" эрхэм зорилготой.</li> <li>Энэхүү эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд "Клин Энержи Ази" ХХК нь дараах зорилт тавьж ажиллана:             <ul style="list-style-type: none"> <li>✓ Монгол Улсын холбогдох кууль тогтоомж болон олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байгаль орчны стандарт шаардлагыг дагуулан биелүүлнэ.</li> <li>✓ Байгаль орчинд халгүй шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.</li> <li>✓ Хэмжээ болохуйн зорилт бүхий "Байгаль орчны менежментийн тогтоомж"-той ажиллана.</li> <li>✓ Байгаль орчинд аюулгүй үйлдвэрлэл явуулахын тулд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг доод түвшинд барина.</li> <li>✓ Цахилгаан үйлдвэрлэх үед байгаль орчны аливаа ослоос урьдчилан сэргийлнэ.</li> <li>✓ Терийн болон нутгийн захиргааны байгууллагатай бүтээх хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.</li> <li>✓ Нутгийн ард иргэдийн уламжлагдаж ирсэн соёл, өв уламжлалыг хүндэтгэж хамгаална.</li> <li>✓ Байгаль орчны талаар авч буй арга хэмжээний талаар нутгийн ард иргэдэд ил тод, мэдлтэй мэдээлнэ.</li> <li>✓ Ажилчдыг байгаль орчны асуул, ослыг харууцлагатай мэдээлдэг зан үйлд суралцуулна.</li> <li>✓ Энэхүү бодлогыг компанийн нийт ажилчид, албан хаагч, гэрээт болон туслан гүйцэтгэгч байгууллагын ажилчид баримтлах үүрэгтэй.</li> </ul> </li> </ul>

### 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


#### 3.1. Техникийн нөхөн сэргээлт

Клин Энержи Ази ХХК нь барилга угсралтын шатанд нийт 30 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг MNS 5916: 2008 газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалтын стандарт, MNS 5917:2008 техникийн ерөнхий шаардлагын стандарт, MNS 17.5.1.19-1992 9х Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлагын дагуу гүйцэтгэж орон нутагт хүлээлгэн өгсөн. 2022 онд техникийн нөхөн сэргээлт төлөвлөгдөөгүй.

#### 3.2. Биологийн нөхөн сэргээлт

Клин Энержи Ази ХХК нь 2017 онд 1.7га талбайд биологийн нөхөн сэргээлт, 2019 онд 3.9 га талбайд биологийн нөхөн сэргээлт гүйцэтгэсэн бөгөөд 2019 онд хийгдсэн нөхөн сэргээлтийн 2.1 га талбайг тус тус орон нутагт хүлээлгэн өгч төлөвлөгөөг биелүүлсэн. 2022 онд биологийн нөхөн сэргээлт төлөвлөгдөөгүй.

*Хүснэгт 7. Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар, байршил, хэмжээ*

#	Байршил	Хэмжээ	Зураг
1.	Кемпийн талбай 4824040.275N 550056.7009E	0.9 га	
2.	Хяналтын байрны авто зогсоол 4826224.327N 550563.383E	1.0 га	
3.	Эд анги хураах талбай 4823171.772N 551684.178	1.0 га	



### 3.3. Орчны тохижилт

Клин Энержи Ази ХХК -ийн ажиллагсад 10 дугаар сарын 26-ны өдөр Цогтцэций сумын байгаль орчны газраас зохион байгуулж байгаа “Мод тарих өдөрлөг”-т оролцож сумын Өгөөмөр багийн нутаг дэвсгэр буюу сумын хуучин наадмын талбайд нийт 90 хайлаас модны суулгацыг сайн дурын үндсэн дээр тарьж сумын нийтийн эзэмшлийн талбайн өнгө үзэмж болон тохижилтод хувь нэмрээ оруулав.



#### 4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дагуу төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй тул арга хэмжээ авах шаардлагагүй гэсэн дүгнэлт гарсан бөгөөд Клин Энержи Ази ХХК нь 2017 оны 3 дугаар сарын 9-ны өдөр Шинжлэх Ухааны Академийн Түүх, Археологийн Хүрээлэнд хандан археологи болон угсаатан зүйн судалгаа хийлгэж аливаа олдвор олдоогүй болохыг баталгаажуулсан.

Мөн 2017 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр Шинжлэх Ухааны Академийн Палентологийн Геологийн Хүрээлэнд хандан палентлогийн хайгуул, судалгааны ажл гүйцэтгүүлсэн бөгөөд энэхүү судалгаагаар төслийн талбайд аливаа палентлогийн олдвор илрээгүй. Станц нь “Түүх, соёлын өв илэрсэн тохиолдолд ажиллах журам”-тай.

#### 5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Станцын үйл ажиллагаанд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн систем хэрэгждэг бөгөөд ажлын байрны эрсдэлийн үнэлгээний журмын хүрээнд аливаа үйлдвэрлэлийн осол, эрсдлээс урьдчилан сэргийлж ажилладаг (Хүснэгт 7).

*Хүснэгт 8. Осол, эрсдэл, гамигаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

№	Арга хэмжээ	Биелэлт	Зураг
1.	Ажилчидад галын аюулаас сэргийлэх сургалт, зааварчилгаа өгөх	2022/07/04 болон 10/03-ны өдөр Гал Импекс ХХК-тай хамтран галын аюулгүй ажиллагааны сургалт, галын дохиолол автоматжуулалтын системийн тухай сургалт дадлага зохион байгуулав. Мөн 2022/10/31-11/30 хооронд Цогтцэций сумын ОБГ-тай хамтран гал унтраах дасгал зохион байгуулахаар төлөвлөв.	

№	Арга хэмжээ	Биелэлт	Зураг
2.	Гал унтраах хэрэгсэл, аюулын гарц, цугларах цэгийг байрлуулах	Станцын хэмжээнд нийт 8 галын сарааны иж бүрдэл, дэд станцад 4кг-ийн ABS хор 24ш, CO2 хор нийт 2ш бий, засвар үйлчилгээний байранд нийт 29ш гал унтраагуур бий. Станцын байрнуудын давхар бүрт гарах гарц, гадна талбайд нийт 2 цугларах тэмдэг хийгдсэн.	
3.	Анхан шатны тусламжийн багаж хэрэгсэлээр хангах, анхны тусламжийн сургалтанд суулгах	Станцын хэмжээнд нийт 4ш анхны тусламжийн хайрцаг, 1 могойнд хатгуулсан хүнд анхны тусламж үзүүлэх зөөврийн хэрэгсэл, 4 зөөврийн анхны тусламжийн хэрэгсэл, 2 нүд угаах хэрэгсэлтэй.	  



№	Арга хэмжээ	Биелэлт	Зураг																									
4.	Тэсэрч дэлбэрэх аюултай түлш, шатах тослох материалыг нарны шууд тусгалаас хамгаалсан байгууламжид байрлуулах	Аюултай бодисыг зориулалтын цементэлж тохижуулсан талбайд хадгалдаг.																										
5.	Аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгөх	Станцын үйл ажиллагаанд мөрдөгддөг “Аюулгүй ажиллагааны сургалт, зааварчилгааны журмын” хүрээнд нийт 6 төрлийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа мөрдөгддөг: урьдчилсан зааварчилгаа, анхан шатны зааварчилгаа, тухайлсан зааварчилгаа, зочны зааварчилгаа, давтан зааварчилгаа. Давтан зааварчилгааны хөтөлбөрийг жил тутам баталж мөрддөг.	<p>T3-BYP-65 Хамаарах: ТЗ-УАЖ-15</p> <p>Батлаа <i>[Signature]</i> Гүйцэтгэх захирал Р. Мянгар</p> <p>2022 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЭЭЛЖИТ ДАВТАН ЗААВАРЧИЛГААНЫ СЭДЭВ</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Сэдэв</th> <th>Агуулга</th> <th>Хариуцах</th> </tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="4">Негдлэгч сэр</td> <td>1</td> <td>ТАД-ын 1-р бүлэг: Ашиглалтын зохион байгуулалт</td> <td>1.1. Зохион байгуулалтын бүтэц ба зорилтууд 1.2. Цацалсан тонног төхөөрөмжийг ашигдалтад хүлээн авах 1.3. Аюуллагсдамыг сургаж бэлтгэх ЭХС 102 тоот тушаал аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм 1.4. Эрчим хүчний үйлдвэрийн ажлын үр шийгт тавих хяналт</td> <td>БОХАБЭА-н мэргэжилтэн</td> </tr> <tr> <td>2</td> <td>Галын аюулгүй байдал</td> <td>• Галын аюулгүй байдлын дүрэм (ТЗ-ДҮР-03) • Гал гарсан үед мөрдөх заавар (Т4-ЗАА-10) • Гал гаргах нөхцөл, гал унтраах анхан шатны хэргэслэлийн нөхцөл, галын торын төрөл ба зориулалт • Гамшгийн үед холбоо барих утас, зугаарах цэгийн байршил</td> <td></td> </tr> <tr> <td>3</td> <td>110/35кВ-н Трансформатор аюулгүй ажиллагаа</td> <td>• Тонноглоомын бүтэц, ажлаах зарчим • Үзлэг хийх аргачлал, хуваарь • Тонноглоомд гарч болох гэмтэлүүд • Гэмтэл гарсан дохиоллолд авах арга хэмжээ • Дэл сэдэв: А-1800 тоолуур, ажиллагааны зарчим • Дэл сэдэв: Станцын Мэхээлийн аюулгүй байдлын журам</td> <td>Засварын инженер, Скад инженер</td> </tr> <tr> <td>4</td> <td>Нэгдсэн сүлжээний дүрэм</td> <td>Арван хоёрдугаар бүлэг: Шуурхай ажиллагааны хүмүүсийн хоорондын эрх, үүрэг, харьцаа 12.1. ДҮТ-ийн шуурхай ажиллагааны хүмүүсийн эрх, үүрэг 12.2. Шуурхай ажиллагааны хүмүүсийн хоорондын харьцаа 12.3. Шуурхай ажиллагааны холбоогоор ДҮТ-ийн диспетчерийг харцах харьцаа 12.4. Рапорт өгөх, мэдээлэл солилцох</td> <td>Эзэлхийн инженер</td> </tr> <tr> <td>Холбогдох сэр</td> <td>ТАД-ын 1-р бүлэг: Ашиглалтын зохион байгуулалт</td> <td>Нэг: Ашиглалтын зохион байгуулалт 1.1. Техник хяналт, шингэлтийн зохион байгуулалтад хийх шалгалт 1.2. Техникийн үйлчилгээ, засвар, шинэчилэлт, өөрчлөлтийн ажлыг гүйцэтгэх 1.3. Техникийн баримт бичиг 1.10. Аюулгүй ажиллагаа 1.11. Галын аюулгүй ажиллагаа 1.13. Техник шингэлтийн дүрмийн биелэлтэнд хүлээх хариуцлага</td> <td>БОХАБЭА-н мэргэжилтэн</td> </tr> </tbody> </table>	№	Сэдэв	Агуулга	Хариуцах	Негдлэгч сэр	1	ТАД-ын 1-р бүлэг: Ашиглалтын зохион байгуулалт	1.1. Зохион байгуулалтын бүтэц ба зорилтууд 1.2. Цацалсан тонног төхөөрөмжийг ашигдалтад хүлээн авах 1.3. Аюуллагсдамыг сургаж бэлтгэх ЭХС 102 тоот тушаал аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм 1.4. Эрчим хүчний үйлдвэрийн ажлын үр шийгт тавих хяналт	БОХАБЭА-н мэргэжилтэн	2	Галын аюулгүй байдал	• Галын аюулгүй байдлын дүрэм (ТЗ-ДҮР-03) • Гал гарсан үед мөрдөх заавар (Т4-ЗАА-10) • Гал гаргах нөхцөл, гал унтраах анхан шатны хэргэслэлийн нөхцөл, галын торын төрөл ба зориулалт • Гамшгийн үед холбоо барих утас, зугаарах цэгийн байршил		3	110/35кВ-н Трансформатор аюулгүй ажиллагаа	• Тонноглоомын бүтэц, ажлаах зарчим • Үзлэг хийх аргачлал, хуваарь • Тонноглоомд гарч болох гэмтэлүүд • Гэмтэл гарсан дохиоллолд авах арга хэмжээ • Дэл сэдэв: А-1800 тоолуур, ажиллагааны зарчим • Дэл сэдэв: Станцын Мэхээлийн аюулгүй байдлын журам	Засварын инженер, Скад инженер	4	Нэгдсэн сүлжээний дүрэм	Арван хоёрдугаар бүлэг: Шуурхай ажиллагааны хүмүүсийн хоорондын эрх, үүрэг, харьцаа 12.1. ДҮТ-ийн шуурхай ажиллагааны хүмүүсийн эрх, үүрэг 12.2. Шуурхай ажиллагааны хүмүүсийн хоорондын харьцаа 12.3. Шуурхай ажиллагааны холбоогоор ДҮТ-ийн диспетчерийг харцах харьцаа 12.4. Рапорт өгөх, мэдээлэл солилцох	Эзэлхийн инженер	Холбогдох сэр	ТАД-ын 1-р бүлэг: Ашиглалтын зохион байгуулалт	Нэг: Ашиглалтын зохион байгуулалт 1.1. Техник хяналт, шингэлтийн зохион байгуулалтад хийх шалгалт 1.2. Техникийн үйлчилгээ, засвар, шинэчилэлт, өөрчлөлтийн ажлыг гүйцэтгэх 1.3. Техникийн баримт бичиг 1.10. Аюулгүй ажиллагаа 1.11. Галын аюулгүй ажиллагаа 1.13. Техник шингэлтийн дүрмийн биелэлтэнд хүлээх хариуцлага	БОХАБЭА-н мэргэжилтэн
№	Сэдэв	Агуулга	Хариуцах																									
Негдлэгч сэр	1	ТАД-ын 1-р бүлэг: Ашиглалтын зохион байгуулалт	1.1. Зохион байгуулалтын бүтэц ба зорилтууд 1.2. Цацалсан тонног төхөөрөмжийг ашигдалтад хүлээн авах 1.3. Аюуллагсдамыг сургаж бэлтгэх ЭХС 102 тоот тушаал аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм 1.4. Эрчим хүчний үйлдвэрийн ажлын үр шийгт тавих хяналт	БОХАБЭА-н мэргэжилтэн																								
	2	Галын аюулгүй байдал	• Галын аюулгүй байдлын дүрэм (ТЗ-ДҮР-03) • Гал гарсан үед мөрдөх заавар (Т4-ЗАА-10) • Гал гаргах нөхцөл, гал унтраах анхан шатны хэргэслэлийн нөхцөл, галын торын төрөл ба зориулалт • Гамшгийн үед холбоо барих утас, зугаарах цэгийн байршил																									
	3	110/35кВ-н Трансформатор аюулгүй ажиллагаа	• Тонноглоомын бүтэц, ажлаах зарчим • Үзлэг хийх аргачлал, хуваарь • Тонноглоомд гарч болох гэмтэлүүд • Гэмтэл гарсан дохиоллолд авах арга хэмжээ • Дэл сэдэв: А-1800 тоолуур, ажиллагааны зарчим • Дэл сэдэв: Станцын Мэхээлийн аюулгүй байдлын журам	Засварын инженер, Скад инженер																								
	4	Нэгдсэн сүлжээний дүрэм	Арван хоёрдугаар бүлэг: Шуурхай ажиллагааны хүмүүсийн хоорондын эрх, үүрэг, харьцаа 12.1. ДҮТ-ийн шуурхай ажиллагааны хүмүүсийн эрх, үүрэг 12.2. Шуурхай ажиллагааны хүмүүсийн хоорондын харьцаа 12.3. Шуурхай ажиллагааны холбоогоор ДҮТ-ийн диспетчерийг харцах харьцаа 12.4. Рапорт өгөх, мэдээлэл солилцох	Эзэлхийн инженер																								
Холбогдох сэр	ТАД-ын 1-р бүлэг: Ашиглалтын зохион байгуулалт	Нэг: Ашиглалтын зохион байгуулалт 1.1. Техник хяналт, шингэлтийн зохион байгуулалтад хийх шалгалт 1.2. Техникийн үйлчилгээ, засвар, шинэчилэлт, өөрчлөлтийн ажлыг гүйцэтгэх 1.3. Техникийн баримт бичиг 1.10. Аюулгүй ажиллагаа 1.11. Галын аюулгүй ажиллагаа 1.13. Техник шингэлтийн дүрмийн биелэлтэнд хүлээх хариуцлага	БОХАБЭА-н мэргэжилтэн																									



## 6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Клин Энержи Ази ХХК нь “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний” дагуу станцын үйл ажиллагаанаас гарах хатуу болон шингэн хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн

байгууллагаар тээвэрлүүлж, зориулалтын цэгт зайлуулдаг.

*Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

№	Арга хэмжээ	Биелэлт	Зураг
1.	Төслийн талбайд хог хаягдал цэвэрлэх ажил зохион байгуулах, нийт ажилчдыг татан оролцуулах	2022/10/05-ны өдөр бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулагдаж станцын талбайн эргэн тойронд байгаа хог хаягдлыг түүж цэвэрлэв.	
2.	Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгасан, тохижуулж, хаягжуулсан цэг байгуулах	Станцын барилга, засвар үйлчилгээний барилга, түр хогын цэгт хог хаягдлыг дараах хуванцар сав, цаас, болон энгийн хаягдал гэсэн 3 төрлөөр ангилан ялгаж хаядаг.	

№	Арга хэмжээ	Биелэлт	Зураг																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																
3.	Төслийн талбайд ил задгай хог хаягдал шатаахгүй байх	Станцын талбайд ил задгай хог хаягдал хаяхыг хориглодог. Ахуйн хэрэглээнээс гарсан хог хаягдлыг 7 хоног тутам нэгдсэн хогийн цэгт тээвэрлэдэг. Одоогоор ил задгай хог хаягдал хаяж зөрчил гаргасан ажилтан байхгүй.																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																	
